



ИХ НАЯД АУДИТ
НЭГДЛЭН БОЛСОН БҮҮТЭЛЭЙН ХАНАЛТИЙН
ХАРААТ БҮС НҮТЭМЖЛЭГДЭГЭН
ХОНДЛОНТИЙН БАНГУУЛАГА

Улаанбаатар хот, СБ.Д. 8-р хороо, River

Castle Business Apartment 605 тоот,

Утас: +976 99077062, 9666-4168

И-мэйл: info@ihnyad.mn

2026.04.01 № СТА-ХК-26/275

“ЖУУЛЧИН ГОВЬ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ

Бид “ЖУУЛЧИН ГОВЬ” ХК (цаашид “компани” гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүү байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “ЖУУЛЧИН ГОВЬ” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлэн үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудит хийхдээ Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг харицулага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

СТА-ХК-26/275



PDF-ийг үүсгэн дугаар...
MOBILE SCANNER

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус компанийн талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул компанийн тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл, бүртгэлийн суурь, бодлогын өөрчлөлтөд тайлант хугацаанд өөрчлөлт ороогүй болно.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Компанийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Компанийн удирдлага нь санхүүгийн тайлангаа СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох, эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах, компанийн чадамжийг үнэлэх, тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Аудиторын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Аудитор нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол улсын "Компанийн тухай хууль"-ийн 95 дүгээр зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

"ИХ НАЯД АУДИТ" ХХК

ЗАХИРАЛ



Х.АРИУНЗУЛ

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2026 оны 04 сарын 01